



MLG

Mongolian
Leading
Group

MLG-Бондын нөхцөл



Үнэт цаасны төрөл	Хаалттай өрийн бичиг		
Бонд гаргагч	Монголиан Лийдинг Групп ХХК		
Нэрлэсэн үнэ	10,000,000 төгрөг		
Тоо ширхэг	200		
Хэмжээ	2,000,000,000 төгрөг хүртэл		
Бондын хугацаа	12 сар	24 сар	36 сар
Жилийн хүү	15.0%	18%	20%
Хүү төлөлт	Жил бүрийн эцэст нэг удаа төлөх		
Бондын эргэн төлөлт	Хугацааны эцэст үндсэн төлбөр төлөх		
Бондын зориулалт	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт		
Бондын баталгаа	Бондын дүнтэй тэнцэхүйц Компанийн хувьцаагаар баталгаа гаргана.		

Үнэт цаас гаргах зориулалт

Төсөл-1

Санхүүгийн салбарт хөрөнгө оруулалт хийх

Өндөр өгөөжтэй, эрсдэл багатай санхүүгийн бизнест хөрөнгө оруулалт хийх.

/Уламжлалт болон финтек/

/Санхүүгийн үйл ажиллагааны үр ашиг, өгөөжийг дараах уудаснаас харна уу./

Төсөл-2

Автын салбарт хөрөнгө оруулалт хийх

Тасралтгүй өсөн нэмэгдэж буй өндөр эрэлттэй автын салбарт 10 гаруй жил үйл ажиллагаа явуулсан мэргэжлийн баг хамт олны хэрэгжүүлж буй шинэ төсөлд хөрөнгө оруулах.

/Автын нэгдсэн үйлчилгээний Авто-Х төслийн танилцуулгаас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу./

Компанийн санхүүгийн давуу талууд



1. Жил бүр өөрийн хөрөнгийн хэмжээ 40-с дээш хувийн өсөлттэй
2. Жил бүр санхүүгийн тайланд магадлан итгэмжлэгдсэн аудитын байгууллагуудаар аудит хийлгүүлдэг.
3. Санхүүгийн Зохицуулах Хорооноос ББСБ-д тавьдаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хамгийн өндөр түвшинд хангаж ажилладаг.




Зээлийн багц 22 тэрбум



Жигнэсэн дундаж хүү 3.5%

Зээлийн чанар



■ Хэвийн

■ Төлөх өдрөөс 1 өдөр хоцорсон ч хугацаа хэтэрсэн ангилалд тайлагнаж харуулав.

MLG бондыг сонгох шалтгаан:



Зээлийн актив 100% барьцаа хөрөнгөөр баталгаажсан.



Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 55.5 тэрбум төгрөг.



Барьцаа хөрөнгүүд 100% даатгагдсан.



Хөдлөх хөрөнгүүд буюу барьцаанд буй автомашинууд GPS төхөөрөмжтэй.

Үнэт цаас худалдан авах заавар

1	Үнэт цаасны танилцуулгатай танилцаж, хэрэгтэй бүх мэдээллээ авах
2	Бонд худалдан авах захиалгыг Монголиан Лийдинг Групп компанийн Япон дахь салбар компани болох MLG-Japan компанийн ажиллантай утсаар эсвэл өөрийн биеэр холбогдож өгнө.
3	MLG-Japan компанийн албан ёсны төлөөлөгчийн дансанд бонд худалдан авах төлбөрөө байршуулна.
4	Бонд худалдан авах гэрээнд талууд гарын үсэг зурснаар бондын эзэмшигч болж бүртгэгдэнэ.



Үнэт цаас эзэмшигчийн эрх:

- Өрийн хэрэгсэл эзэмшигч нь дараах хэрэгсэл, баримтууд болон мэдээллийг шаардах эрхтэй. Үүнд: (а) Компанийн санхүүгийн тайлантай танилцах, (б) Өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн үнийн мэдээг хүлээн авах, (в) Өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн арилжааны саналыг хүлээн авах, (г) Хуульд заасан бусад.
- Өрийн хэрэгсэл эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй Өрийн хэрэгслийг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжиж, захиран зарцуулах.
- Хугацааны эцэст Өрийн хэрэгслийг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хуримтлагдсан хүүг төлөхийг шаардах, эсвэл хугацааны эцэст Өрийн хэрэгслийн баталгаа гаргагчийг Өрийн хэрэгслийн эргэн төлөлтийг хийхийг шаардах болон Монгол улсын хуульд заасан бусад холбогдох хууль, журамд заасан эрхүүдийг эдэлнэ. Бондын төлбөр тооцоо, гэрээ баталгаажилт

Үнэт цаас гаргагчийн үүрэг:

- > Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирол, алдангийг үл маргах журмаар төлж барагдуулах үүрэгтэй.
- > Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг гэрээнд заасан дүнгээр цаг хугацаанл шилжүүлнэ.
- > Үнэт цаасны хүүгийн орлогоос хуулийн дагуу татвар суутган шилжүүлнэ.
- > Өрийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд Үнэт цаасны батлан даалтын гэрээний дагуу зохих арга хэмжээг авч Үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах.
- > Өрийн хэрэгслийн нэрлэсэн үнээр хугацааны эцэст хөрөнгө оруулагчаас буцаан худалдаж авах, хуримтлагдсан хүүгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулах.
- > Өрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэл хүргэх.
- > Өрийн хэрэгсэл борлуулснаас олсон орлогыг үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зорилтын дагуу зарцуулах.

Татварын зохицуулалт:

Хувь хүний татвар - Бондын хүү төлөх үед үнэт цаас гаргагч компани хуулийн дагуу заасан хувь хэмжээгээр татвар суутган худалдан авагчид шилжүүлнэ.

Аж ахуйн нэгжийн татвар - Компани өөрийн үйл ажиллагаанаас олсон ашгаа санхүү, татварын тайланд тусган мэдүүлнэ.